



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг)¹

НЭГЖЛЭГИЙН ЯВЦАД ИЛРҮҮЛСЭН ГАР УТАСНЫ ТҮГЖЭЭГ СЭЖИГТНИЙ ХУРУУНЫ ХЭЭГ АШИГЛАН ТАЙЛСАН НЬ ХУУЛЬД НИЙЦСЭН ГЭЖ ҮЗЭВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2 StR 232/24

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

Шийдвэрийн төлөв байдал: Муж Улсын шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь 2017 оныг хүртэл хүүхдийн цэцэрлэгт сурган хүмүүжүүлэгчээр ажилласан бөгөөд ажиллаж байх хугацаандаа хүүхэд оролцуулан садар самуун агуулга бүхий зүйлийг олж авсан, хадгалсан гэмт хэрэгт холбогджээ. Мьюхен Мужийн шүүхээс шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн 184б дугаар зүйлд заасан Хүүхэд оролцуулан садар самуун агуулга бүхий зүйл тараах, олж авах, эзэмших гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 1 жил 1 сарын хугацаагаар хорих ял оногдуулж, уг хорих ялыг тэнссэн. Мөн шүүгдэгчийн хүүхэд асрах, сурган хүмүүжүүлэгчээр ажиллах зэрэг мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг бүх насаар нь хассан байна. 2020 онд шүүгдэгч Ковид-19 халдварын цар тахлын улмаас хүүхдийн өдөр өнжүүлэх төв болон цэцэрлэг хаагдсаныг далимдуулан хувиараа хүүхэд асрах үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд хүүхэд оролцуулан садар самуун агуулга бүхий эд зүйл олж авах, хадгалах гэмт хэрэгт дахин холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Муж Улсын шүүхээс шүүгдэгчийг мэргэжлийн үйл ажиллагаа явуулах хоригийг зөрчих болон хүүхэд оролцуулан садар самуун агуулга бүхий эд зүйлийг олж авсан, хадгалсан гэмт хэргийг тус тус үйлдсэн гэм буруутайд тооцож, 2 жил 6 сарын хугацаагаар хорих ял оногдуулсан.

Шүүгдэгч уг шийдвэрийг эс зөвшөөрч хяналтын шатны шүүхэд процессын эрх зүйн хэм хэмжээг дараах байдлаар зөрчсөн гэх агуулгаар гомдол гаргасан байна.

Прокуророос мэргэжлийн үйл ажиллагаа явуулах хоригийг зөрчих гэмт хэрэгт холбогдуулан шүүгдэгчийн орон байранд нэгжлэг хийх ажиллагаа явуулах шаардлагатай тул холбогдох зөвшөөрлийг Кельн орон нутгийн шүүхээс хүссэн. Прокурорын хүсэлтэд “гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан шүүгдэгчийн гар утсыг олох

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://juris.bundesgerichtshof.de/cgi-bin/rechtsprechung/document.py?Gericht=bgh&Art=en&Datum=+Aktuell&Sort=2057&Seite=21&nr=141600&anz=871&pos=634>



зорилгоор түүний орон байранд нэгжлэг хийх” хэмээн нэгжлэг хийх зорилгыг тодорхой тусгажээ. Шүүхээс орон байранд нэгжлэг хийхийг зөвшөөрсөн шийдвэр гаргасан бөгөөд уг шийдвэрийн дагуу мөрдөгч шүүгдэгчийн орон байранд нэгжлэг хийж, 2 ширхэг гар утас илрүүлсэн байна. Шүүгдэгч өөрийн сайн дурын үндсэн дээр гар утасны түгжээг тайлж өгөөгүй тул мөрдөгч түүний баруун гарын долоовор хурууг гар утасны түгжээ тайлах хэсэгт хүчээр байрлуулан, гар утасны түгжээг тайлж, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ажилтанд эд мөрийн баримт болох гар утсыг хүлээлгэн өгчээ.

Шүүгдэгчийн өмгөөлөгч гар утасны түгжээг дээрх аргаар тайлсан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн, шүүгдэгч гэм буруугүйгээ нотлох үүрэг хүлээхгүй бөгөөд түүний шударгаар шүүлгэх эрх болон хувийн мэдээллээ өөрөө тодорхойлох эрхийг тус тус зөрчсөн. Иймээс гар утсанд хадгалсан мэдээллийг шүүх нотлох баримтаар үнэлж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон нь хууль зөрчсөн гэх агуулгаар гомдол гаргасан.

Холбооны Улсын дээд шүүхээс шүүгдэгчийн гаргасан дээрх гомдлыг үндэслэлгүй гэж үзсэн бөгөөд дараах тайлбарыг хийжээ.

I. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчөөгүй

Сэжигтний гар утсан дахь мэдээлэлд зөвшөөрөлгүй хандах нь Үндсэн хууль (1949)²-ийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллээ өөрөө тодорхойлох эрхийг ноцтой зөрчиж байгаагийн илрэл. Гэхдээ шүүгчийн зөвшөөрлийн үндсэн дээр явагдаж буй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд уг эрхийг хязгаарлах боломжтой.

Сэжигтний хуруугаар түүний биометрийн өгөгдлөөр түгжигдсэн гар утасны түгжээг хүчээр тайлах эрхийг мөрдөгчид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81b болон 94 дүгээр зүйлд тус тус олгосон байна. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 81b дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эсвэл таниулах ажиллагаа явуулах зорилгоор шүүгдэгчийн хүсэл зоригийн эсрэг түүний гэрэл зураг болон хурууны хээг авахыг зөвшөөрнө” хэмээн заасан. Гар утасны түгжээ тайлах мэдрэгч дээр сэжигтний хурууг байрлуулсан нь сэжигтний бие махбодын аль нэг хэсгийг тогтоох зорилгоор хийгдсэн учраас Эрүүгийн процессын хуулийн 81b дүгээр зүйлийн 1 дэх хэсэг заасан арга хэмжээтэй адил утгаар ойлгоно. Иймээс мөрдөгч гар утсыг нээх эрхтэй байна.

II. Пропорциональ зарчимд нийцсэн.

Дээрх ажиллагаа нь пропорциональ зарчимд нийцсэн байна. Пропорциональ зарчмын дагуу сэжигтний холбогдсон гэмт хэргийн хүнд, гэмт хэрэгт сэжиглэх хангалттай үндэслэл байгаа эсэх мөн гар утсанд хадгалсан мэдээлэл нь нотолгооны ач холбогдолтой эсэх зэргийг хувь хүний мэдээллээ хамгаалах эрхийн эсрэг жинлэн үзнэ. Шүүгдэгч нь Эрүүгийн хуулийн 145с дугаар зүйлд зааснаар мэргэжлийн үйл

² Grundgesetz für die Bundesrepublik Deutschland, 1949, <https://www.gesetze-im-internet.de/gg/index.html>, (Сүүлд үзсэн: 2025.12.08).



ажиллагаа явуулахыг хориглосон хориглолтыг зөрчсөн гэсэн үндэслэл бүхий сэжиг байгаа мөн түүнийг хүүхэд оролцуулсан садар самуун бүхий зүйлсийг үйлдвэрлэсэн хэргээр өмнө нь ял шийтгүүлж байсан зэргийг авч үзвэл шүүгдэгчийн гар утсанд нэвтэрсэн нь пропорциональ зарчимд нийсэн байна.

III. Нотлох баримтыг ашиглахыг хориглохгүй.

Холбооны Улсын дээд шүүхээс сэжигтний хүсэл зоригийн эсрэг гар утасны түгжээг тайлж, олж авсан мэдээллийг нотлох баримтаар ашиглах боломжтой гэж үзсэн. Учир нь дээрх ажиллагаа пропорциональ зарчимд нийцсэн байна хэмээн тус тус дүгнэжээ.

---o0o---